

ХХААХҮЯ, Монголын бэлчээрийн менежментийн холбоо, “Ногоон алт” тосолтэй хамтран “Бэлчээрийн тухай хуулийн тосол”-ийн хэлэлцүүлгийг 2011 оны 3-р сарын 17-ны одор зохион байгууллаа.

Энэхүү хэлэлцүүлгийн үндсэн зорилго нь мэргэжилтнүүдээс санал авах замаар УИХ-д оргон барьсан хуулийн төслийг боловсронгуй болгох үндсэн чиглэлүүдийг хамтран тогтох явдал байв.

Хэлэлцүүлэгт хуулийн төслийг санаачлагчдын толоолол, төслийг боловсруулсан ажлын хэсэг, торийн ба иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээ, мэргэжлийн байгууллагуудын толоолол болох эрдэмтэн судлаачид, тухайн чиглэлээр хэрэгжиж буй тосол, хотолборнуудийн толоолол оролцлоо.

УИХ-ын Байгаль орчин, хvнс, ходоо аж ахуйн байнгын хорооны Референт Б.Мяхдадаг хурлыг нээж, ХХААХҮЯ-ны Газрын дарга Б.Биньее даргалав.

ХХААХҮЯ-ны Газрын дарга Биньее УИХ-д оргон баригдсан бэлчээрийн тухай хуулийн төслийн үндсэн үзэл баримтлалын талаар, МБМХ-ны Гүйцэтгэх захирал Д.Дорлигсүрэн торийн байгууллагаас болон МБМХ-оос боловсруулсан бэлчээрийн тухай хуулийн төслүүдийг харьцуулан судалсан талаар танилцуулж оролцогчид асуулт тавих, саналаа хэлэх байдлаар байр сууриа илэрхийллээ.

Хурлаар дараах үндсэн асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Бэлчээрийн талаар тороос баримтлах зарчим,
2. Бэлчээрийг ашиглалтын зориулалтаар хэрхэн ангилах, тvvний хил заагийг тогтоох,
3. Отрын нооц бэлчээрийн зохицуулалт,
4. Бэлчээр эзэмшигч, ашиглагч субъектүүдийн зохион байгуулалтыг хэрхэн зохицуулах,
5. Бэлчээрийг эзэмшvvлэх, ашиглуулах хувилбарууд гэх зэрэг үндсэн үзэл баримтлалуудыг авч хэлэлцэв.

Хэлэлцүүлгийн үр дvнгээс:

1. Тороос баримтлах зарчмын талаар хэлэлцэж дараах байдлаар тогтлоо.

Үүнд:

- Оргон баригдсан хуулийн тосолд тусгагдсан “бэлчээр торийн хяналтанд байх” гэсэн зарчим дээр нэмж МБМХ-ны боловсруулсан төслийн хувилбарын “тороос бэлчээрийн толов байдалд хяналт тавих, үнэлэлт огох” гэсэн саналыг нэмж тусгахаар тогтлоо. Оороор
 - хэлбэл тор омчлох эрхээ хэрэгжvvлэхдээ зовхон хяналт тавихаас гадна үнэлгээ хийх зарчмыг баримтлах нь зvйтэй гэсэн санал дэмжигдсэн.
 - МБМХ-ны боловсруулсан төслийн хувилбарын “Бэлчээрийн даацад тохируулан

малын тоог зохицуулах” гэсэн тороос баримтлах зарим байх нь зов юм гэсэн санал мон дэмжигдлээ.

- Оргон баригдсан хуулийн тосолд тусгагдсан бэлчээрийг зовхон эзэмшүүлэх асуудлыг тороос баримтлах зарчим болгож тусгасан нь хэтэрхий ороосгол юм гэж дүгнээд тослийн 4.1.3 /бэлчээрийг малчдын бүлэг, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд зовхон мал аж ахуй эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх/ -ийг хасах нь зов гэж тогтлоо.

2. МБМХ-ны боловсруулсан тослийн үндсэн үзэл баримтлалын нэг болох бэлчээрийг ашиглалтын зориулалтаар нь ангилсан асуудлыг хэлэлцсэнээр:

- Отрын бэлчээр (отрын бэлчээрээ дотор нь бас ангилж болох юм гэсэн саналыг зарим оролцогчид гаргав)

- Дамжин онгорох бэлчээр (амьдрал дээр их товогтэй асуудлын талаар санал гаргасан)

- Тосгон, суурин газар орчмын бэлчээр (энэ ангиллын бэлчээрийг хассан ч болно гэсэн санал бас байв)

- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээр (эрчимжсэн **суурин** мал аж ахуй эрхлэх хэмээн оорчлох саналыг гаргав)

- Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бэлчээр гэж ангилан үзэж болох эсэх,

- Дээрх ангилалтай холбоотойгоор бэлчээрийн ангиллын дагуу түүний хил зааг тогтоох асуудлыг их зов шийдэх хэрэгтэй гэж үзэв. Оороор хэлбэл хилийн зааг гэдэг үгийг хүрээ, шугам, зааг, эсхүл хэмжээ, байршил гэх зэрэг ухагдахуунуудын аль нь оновчтой болохыг сайн бодолцох нь зов гэж тогтлоо.

- Бэлчээрийн тухай хуулийн тослийг боловсронгуй болгохоор дахин ажлын хэсэг байгуулагдсан тохиолдолд УИХ-д оргон баригдсан бэлчээрийн тухай хуулийн тосолд бэлчээрийг ашиглалтын зориулалтаар нь хэрхэн ангилах асуудлыг хэлэлцэж тогтох нь зүйтэй хэмээн үзэв.

3. Отрын бэлчээрийн харилцааны зохицуулалтыг хэлэлцсэнээр:

- Аймаг дундын отрын бэлчээрийн хилийн заагийг УИХ, эсвэл Засгийн газар тогтоох гэдэг дээр санал хуваагдсан тул дараагийн ажлын хэсэг шийдэх нь зүйтэй гэж тогтлоо.

4. Бэлчээр эзэмшигч, ашиглагч субъектүүдийн зохион байгуулалтыг хэрхэн зохицуулах

талаар **хоёр өөр үзэл баримтлал дэвшүүлэн** ярилцсанаар оролцогчид харилцан ойлголцсон боловч зовхон нэг одрийн хэлэлцүүлгээр нэгдсэн үзэл баримтлал болгон тогтох боломжгүй гэж үзсэн. Энэ нь:

- Торийн байгууллагын хувьд, малчин орхвудийн **сайн дурын үндсэн дээр** бий болсон хамтын бүлгийн зохион байгуулалт хийх,

- МБМХ-ны хувьд, газар нутагт нь түшиглэж түүн дээр амьдарч, бэлчээрийн үр шимийг хүртэж байгаа **бүх малчин орхвудийг заавал зохион байгуулалтанд оруулж** малчдын зохион байгуулалтыг бий болгох гэсэн эсрэг тэсрэг үзэл баримтлал бий. Эдгээр хоёр үзэл баримтлал нь нэр томъёоны хувьд ялгаагүй боловч эзэмшигч, ашиглагч субъектүүдийн зохион байгуулалтыг хэрхэн зохицуулах вэ гэдэг нь зарчмын ялгаатай юм.

5. Бэлчээрийг эзэмшүүлэх, ашиглуулах хувилбаруудын талаар хэлэлцэн ашиглуулах эрхийг мон адил баталгаажуулах нь зүйтэй гэж үзлээ.

6. Бэлчээрийг харилцааг тусгай хуулиар зохицуулахад **уламжлалд тулгуурласан, нүүдэл хийх бололцоо нөхцлийг хангахуйц байдлаар хуульчлах нь зүйтэй** хэмээн үзэж байгаа МБМХ-ны үндсэн үзэл баримтлалын талаар хэлэлцэж оролцогчид хвлээн зовшоорсон ч оргон баригдсан хуулийн тосолд чухам ямар байдлаар тусгах асуудлыг дараагийн ажлын хэсэг хэлэлцэж шийдэх хэрэгтэй гэж дүгнэлээ.

7. Хэлэлцэж тогтсон асуудлын хүрээнд бэлчээрийн харилцааны эрхзүйн орчинг хэрхэн боловсронгуй болгох талаар бэлчээрийн толов байдал, бэлчээрийн тухай хууль гаргах шаардлагатай эсэх, бэлчээрийг эзэмшүүлэх эсэх асуудал, хэрэв эзэмшүүлэх тохиолдолд аль улирлын бэлчээрийг хэнд эзэмшүүлэх, оволжооний нутаг бэлчээр заагтай байх эсэх, бэлчээрийн маргаан, бэлчээрийн даацыг яаж зохицуулах, бэлчээрийн талаар хамгийн хүндрэлтэй асуудал гэх зэрэг асуулгаар **ард нийтийн санал авах асуулгыг хамтран боловсрууллаа**

8. Санал авах асуулгыг ходоо орон нутагт хэрхэн зохион байгуулах талаар **ХХААХҮЯ-а ас нэгдсэн удирдамж**

/аймаг, сум, хугацаа, оролцогчид гэх зэрэг санал асуулгыг хэрхэн зохион байгуулах бүх асуудлыг багтаах/

гарган хамтран ажиллахаар

шийдвэрлэсэн болно.

9. Ард нийтийн санал асуулгыг 2011 оны 06 сард авч дуусгахаар тогтлоо.

10. Эцэст нь “Бэлчээрийн тухай хууль”-ийн тосол боловсруулах ажлын хэсэг байгуулагдсаны дараа **энэхүү хэлэлцүүлгээс гарсан үр дүнг албан ёсоор танилцуулж** тосолд оорчлолт оруулах нь зүйтэй гэж үзлээ.